

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/059/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ахлах аудитор: Д.Назгүл
	Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт.....	16
5.2 Албан шаардлага.....	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.АРМАНБЕК ТАНАА

2025.02.25 № 230
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 4,459.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 4,349.9 сая төгрөг зарцуулж, 98 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

832502000256

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.АЙГУЛ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>174,065,734.82</u>	<u>273,245,967.21</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	61,087,759.82	115,817,544.21
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	61,087,759.82	115,817,544.21
3121	Төгрөг	61,087,759.82	115,817,544.21
31211	Төрийн сангийн харилцах	61,087,759.82	115,817,544.21
33	АВЛАГА	2,762,660.00	2,762,660.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,762,660.00	2,762,660.00
35	БАРАА МАТЕРИАЛ	110,215,315.00	154,665,763.00
354	Хангамжийн материал	110,215,315.00	154,665,763.00
35410	Бичиг хэргийн материал	5,695,500.00	7,081,090.00
35420	Аж ахуйн материал	84,073,450.00	120,302,762.00
35440	Түлш, шатах тослох материал	-	914,000.00
35460	Хүнсний материал	20,446,365.00	26,367,911.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,140,504,242.74</u>	<u>3,564,749,002.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,140,504,242.74	3,564,749,002.33
392	Биет хөрөнгө	3,103,140,724.39	3,527,598,969.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,002,510,457.00	3,097,510,457.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(280,922,373.88)	(320,833,188.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	271,801,609.50	583,899,387.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(147,242,159.05)	(191,787,588.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	230,416,564.00	335,617,395.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(97,063,720.18)	(116,846,980.66)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	13,000,000.00	13,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,986,890.00	11,986,890.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(749,999.97)
39217	Ном	98,653,457.00	115,802,598.23
393	Биет бус хөрөнгө	37,363,518.35	37,150,032.50
39301	Програм хангамж	2,173,239.00	2,173,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(773,720.65)	(987,206.50)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,964,000.00	35,964,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,314,569,977.56</u>	<u>3,837,994,969.54</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>45,447,142.94</u>	<u>177,797,713.24</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45,447,142.94	177,797,713.24
413	Өглөг	45,447,142.94	177,797,713.24
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	36,791,307.00	175,932,713.24
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	945,806.00	1,865,000.00
4136	Бусад өглөг	7,710,029.94	-
41361	Байгууллагад төлөх өглөг	7,710,029.94	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,269,122,834.62</u>	<u>3,660,197,256.30</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,269,122,834.62	3,660,197,256.30
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,988,658,085.00	1,988,658,085.00
51101	Өмч: - төрийн	1,988,658,085.00	1,988,658,085.00
512	Хуримтлагдсан үр дүн	280,596,717.50	671,671,139.18
51210	Өмнөх үеийн үр дүн	208,088,209.95	280,596,717.50
51220	Тайлант үеийн үр дүн	72,508,507.55	391,074,421.68

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	999,868,032.12	999,868,032.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,314,569,977.56	3,837,994,969.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,126,450,357.00	4,901,341,467.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,873,057.00	497,996,162.23
120	Нийтлэг татварын бус орлого	90,873,057.00	497,996,162.23
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	90,873,057.00	464,812,550.23
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,000.00	1,243,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	90,413,057.00	463,568,950.23
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	33,183,612.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,035,577,300.00	4,403,345,305.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,803,444,300.00	3,984,385,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,803,444,300.00	3,984,385,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	232,133,000.00	418,959,405.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232,133,000.00	418,959,405.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,041,958,030.31	4,510,267,045.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,041,958,030.31	4,510,267,045.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,948,086,469.31	4,386,508,361.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,125,391,814.18	3,038,645,056.64
210101	Үндсэн цалин	1,441,974,005.55	1,833,871,384.23
210102	Нэмэгдэл	553,219,199.56	1,030,804,214.09
210104	Урамшуулал	130,198,609.07	170,626,558.32
210105	Гэрээт ажлын хөлс	-	3,342,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,713,036.00	515,152,449.60
210201	Тэтгэврийн даатгал	176,510,500.00	354,368,003.60
210202	Тэтгэмжийн даатгал	20,903,836.00	38,606,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,613,300.00	12,919,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,153,200.00	16,169,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,532,200.00	93,089,646.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	229,878,176.00	419,762,625.00
210301	Гэрэл, цахилгаан	14,531,176.00	14,841,005.00
210302	Түлш, халаалт	215,347,000.00	404,921,620.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,005,010.00	-
210401	Бичиг хэрэг	23,322,300.00	
210402	Тээвэр, шатахуун	3,470,870.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,211,840.00	
2105	Нормативт зардал	174,086,914.94	182,347,814.06
210502	Хоол, хүнс	174,086,914.94	182,347,814.06

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	927,027.00	100,000.00
210604	Урсгал засвар	927,027.00	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,390,000.00	38,439,554.23
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,390,000.00	38,439,554.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,694,491.19	192,060,862.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,559,600.00	86,857,871.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,348,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94,786,891.19	105,202,990.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,871,561.00	123,758,684.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,716,714.00	123,758,684.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	93,716,714.00	100,658,084.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	23,100,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	154,847.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	154,847.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	84,492,326.69	391,074,421.68
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,983,819.14	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	11,983,819.14	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(11,983,819.14)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	72,508,507.55	391,074,421.68

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,036,037,300.00	4,404,588,905.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,000.00	1,243,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	460,000.00	1,243,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	460,000.00	1,243,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,000.00	1,243,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,035,577,300.00	4,403,345,305.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,803,444,300.00	3,984,385,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,803,444,300.00	3,984,385,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	232,133,000.00	418,959,405.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	232,133,000.00	418,959,405.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,925,233,971.18	4,283,980,320.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,925,233,971.18	4,283,980,320.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,825,381,124.18	4,157,943,660.61

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,088,941,434.18	3,035,591,300.00
210101	Үндсэн цалин	1,405,523,625.55	1,806,075,699.93
210102	Нэмэгдэл	553,219,199.56	1,059,457,341.75
210104	Урамшуулал	130,198,609.07	170,058,258.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	259,456,100.00	379,449,000.00
210201	Тэтгэврийн даатгал	176,402,500.00	258,025,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	20,765,400.00	30,355,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,603,000.00	15,178,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,153,200.00	15,178,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	41,532,000.00	60,711,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	229,888,476.00	417,599,405.00
210301	Гэрэл, цахилгаан	13,888,600.00	14,841,005.00
210302	Түлш, халаалт	215,999,876.00	402,758,400.00
2105	Нормативт зардал	176,537,307.00	182,988,741.68
210502	Хоол, хүнс	176,537,307.00	182,988,741.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,099,977.00	1,360,000.00
210604	Урсгал засвар	2,099,977.00	1,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,560,000.00	39,836,054.23
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,560,000.00	39,836,054.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,897,830.00	101,119,159.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,735,730.00	79,044,659.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,162,100.00	22,074,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,852,847.00	126,036,660.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	99,698,000.00	126,036,660.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	99,698,000.00	102,648,060.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		23,388,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	154,847.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	154,847.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>110,803,328.82</u>	<u>120,608,584.39</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	66,015,500.00	65,878,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	66,015,500.00	65,878,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	66,015,500.00	65,878,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	66,015,500.00	65,878,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(66,015,500.00)</u>	<u>(65,878,800.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	44,787,828.82	54,729,784.39
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,299,931.00	61,087,759.82

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	61,087,759.82	115,817,544.21
-----------	--	---------------	----------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	208,088,209.95	3,206,258,107.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			9,643,780.00	9,643,780.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,988,658,085.00	1,009,511,812.12	208,088,209.95	3,206,258,107.07
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-9,643,780.00		-9,643,780.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Тайлант үеийн үр дүн			72,508,507.55	72,508,507.55
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	999,868,032.12	280,596,717.50	3,269,122,834.62
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	999,868,032.12	280,596,717.50	3,269,122,834.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,988,658,085.00	999,868,032.12	280,596,717.50	3,269,122,834.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
Тайлант үеийн үр дүн			391,079,222.68	391,079,222.68
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,988,658,085.00	999,868,032.12	671,675,940.18	3,660,202,057.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		61,087,759.82
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,459,930,205.00	4,349,859,120.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,459,930,205.00	4,349,859,120.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,323,423,505.00	4,223,822,460.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,094,344,300.00	3,035,591,300.00

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	1,929,039,900.00	1,806,075,699.93
210102	Нэмэгдэл	1,016,227,700.00	1,059,457,341.75
210104	Урамшуулал	149,076,700.00	170,058,258.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	386,793,200.00	379,449,000.00
210201	Тэтгэврийн даатгал	263,019,300.00	258,025,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	30,943,400.00	30,355,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,471,800.00	15,178,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	15,471,800.00	15,178,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	61,886,900.00	60,711,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	417,599,405.00	417,599,405.00
210301	Гэрэл, цахилгаан	14,841,005.00	14,841,005.00
210302	Түлш, халаалт	402,758,400.00	402,758,400.00
2105	Нормативт зардал	208,471,300.00	182,988,741.68
210502	Хоол, хүнс	208,471,300.00	182,988,741.68
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,360,000.00	1,360,000.00
210604	Урсгал засвар	1,360,000.00	1,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,585,000.00	50,140,817.93
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	700,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	51,885,000.00	50,140,817.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	162,270,300.00	156,693,196.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,120,500.00	134,618,696.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,149,800.00	22,074,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	136,506,700.00	126,036,660.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,506,700.00	126,036,660.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	113,118,100.00	102,648,060.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,388,600.00	23,388,600.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,459,930,205.00	4,404,588,905.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,984,385,900.00	3,984,385,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,984,385,900.00	3,984,385,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	418,959,405.00	418,959,405.00
132001	Орон нутгийн төсвөөс	418,959,405.00	418,959,405.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	56,584,900.00	1,243,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000.00	1,243,600.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	55,884,900.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		61,087,759.82
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		115,817,544.21
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	130	135
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	90	90
620003	Үйлчлэх ажилтан	39	44
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	130	135
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	89	89
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	41	46

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургууль 2024 онд "Эрдэм мэдлэгээрээ гэрэлт ирээдүйгээ цогцлоон бүтээх шинэ үеийн шилдэг сурагчдыг бэлтгэх" эрхэм зорилгын хүрээнд "Аймгийн түвшний манлайлагч сургууль болох" зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба 2024 онд хяналт шалгалтад хамрагдаагүй байна.

Сургууль нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирлын тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 523.4 сая төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	61087.76	115817.54	54729.78
Авлага	2762.66	2762.66	0.00
Бараа материал	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгө	110215.32	154665.76	44450.45
Нийт хөрөнгө	3140504.24	3564749.00	424244.76
Өр төлбөр	<u>3314569.98</u>	<u>3837994.97</u>	<u>523424.99</u>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	45447.14	177797.71	132350.57
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3269122.83	3660197.26	391074.42

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 115.8 сая төгрөг болж 54.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага дансанд оны эхэнд 2.7 сая төгрөгийн ажиллагсдаас авах авлагатай байсныг барагдуулаагүй, Авлагын насжилт 0-3 жил байна.

Бараа материал данс оны эцэст 154.7 сая төгрөг болж оны эхнээс 44.4 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 396.3 сая төгрөгийн бараа материал худалдан авсан ба үнэ төлбөргүй 33.2 сая төгрөгийн бараа материал авсан байна. Бичиг хэрэг 7.1 сая, хүнсний материал 26.4 сая төгрөгийн, аж ахуйн материал 152.5 сая төгрөгийн, түлш, шатах, тослох материал 0.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,564.7 сая төгрөг болж 424.2 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 65.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 463.6 төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

Өр төлбөр дансанд оны эхэнд хувь хүний орлогын албан татварт 36.7 сая төгрөгийн, үдийн хоолны зардалд 3.4 сая, хөрөнгийн зардлын 1.5 сая, шатахууны зардалд 1.0 сая, бичиг хэргийн зардалд 1.0 сая төгрөгийн өглөгтэй ба оны эцэст НДШ-д 108.6 сая төгрөгийн, хувь хүний орлогын албан татварт 66.9 сая төгрөгийн, түлш халаалтын зардалд 1.8 сая төгрөгийн өртэй гарсан байна.

Шалтгаан нь: 2022 онд явагдсан шүүр ажиллагаагаар тул БЕГ-аас хийсэн шалгалтаар тус сургуулийн батлагдсан орон тоо 15-аар хэтрэлттэй гарч илүү орон тоонд ажиллаж байгаа хүмүүсийг чөлөөлөх талаар чиглэл өгсний дагуу 7 хүнийг чөлөөлж, 3 хүнийг тэтгэвэрт гарсан хүний оронд хүн авахгүйгээр зохицуулж ажиллуулсан ба одоо 5 орон тоо илүү байгаатай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 391.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 391.1 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын 2024 оны анх батлагдсан төсөв 3,011.8 сая төгрөг байна. Үүнд: Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,259.0 сая, орон нутгийн төсвөөс 418.9 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны анх батлагдсан төсвийг 1,448.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 4,459.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Анх батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,175.3 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 146.9 сая, нормативт зардлыг 12.4 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 52.6 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 28.6 сая төгрөгөөр, үдийн хоолны зардлыг 8.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,044.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 419.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,984.4 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 419.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урьд оны үлдэгдлээс 61.1 сая төгрөгийн, нийт 4,465.0 сая төгрөгийн төсвөөр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,348.6 сая төгрөг буюу 97.4 хувьтай буюу дансанд 116.4 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Ерөнхий боловсрол				
1	Мэдээлэл технологийн үйлчилгээ	3,958.10	0.00	-3,958.10	0.00%
2	Байр ашиглалтын үйлчилгээ	5,627.10	5,627.10	0.00	100.00%
3	Хѳхэд хамгаалал	5,695.60	4,967.66	-727.94	87.22%
4	Сургалт семинар	3,960.00	3,788.00	-172.00	95.66%
5	Эрүүл мэндийг дэмжих	7,040.70	7,040.70	0.00	100.00%
6	үдийн цай хөтөлбөр	113,118.10	102,648.06	-10,470.04	90.74%
7	Дотуур байрны үйлчилгээ	891,968.60	866,485.63	-25,482.97	97.14%
8	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	46,675.40	46,143.24	-532.16	98.86%
9	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	17,621.30	14,572.74	-3,048.56	82.70%
10	Бичиг үсгийн боловсролын хөтл	34,359.50	34,284.20	-75.30	99.78%
11	Боловсролын стандарт, сургалты	2,707,547.20	2,639,185.67	-68,361.53	97.48%
12	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	196,778.90	196,778.90	0.00	100.00%
13	Сурах бичгийн тїрээс	700.00	0.00	-700.00	0.00%
14	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	9,878.40	8,134.22	-1,744.18	82.34%
15	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	419,500.00	418,959.41	-540.59	99.87%
	Дүн	4,464,428.90	4,348,615.52	-115,813.38	97.41%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд батлагдсан төсвийн хүрээнд 398.0 сая төгрөгийн бараа материал, 65.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,041.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 30.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шалгахаар төлөвлөсөн 36 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлж, хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

Боловсролын байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар анхаарах асуудлын дүн дараах байдалтай байна. Үүнд:

Байгууллагын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалтад, засвар үйлчилгээ хийх болон цэвэрлэгээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Хувьсах зардлын хуваарилалт, зарцуулалт нь Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” болон төсөвтэй нийцэж байна. Чанарын хувьд тухайн жилд суралцаж байгаа сурагчийн элсэлтийн болон төгсөлтийн статистик мэдээ, ажиллаж байгаа орон тооны статистик мэдээллүүдэд үндэслэн Боловсролын яамнаас хянаж хуваарилалтыг хийдэг байна. Суурь болон бусад хувьсах зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг зөв тооцсон байна. Оны эцэст төрийн сангийн гүйлгээ хаасны дараа санхүүжилт орж ирсэнтэй холбоотой харилцах дансандаа үлдэгдэлтэй гарсан байна.

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүрээр тооцогдсон зардлууд бодит зардлуудтай нийцэж байна. Төсвийн хуваарилалт зөв тооцоологдсон ба алдаа гараагүй байна.

Хувьсах зардлын санхүүжилтийн үр өгөөжийг боловсрол, сургалтын чанар, гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгааг үнэлсэн эсэх нь тодорхойгүй байна. Үр дүнгийн мэдээллийг хууль, тогтоомжид заасны дагуу бүртгэж, тайлагнасан байна. Боловсролын үнэлгээний төвөөс багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг улирал тутам хийж, болзол хангасан багш нарт үр дүнгийн урамшуулал олгодог ба тус сургуулийн 41 багш 2024 онд урамшуулал авсан байна.

Багш, ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо зөв хийгдсэн ба нэмэгдэл хөлс, урамшуулал зөв хуваарилагдаж, тайлагнагдсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлсэн асуудал байхгүй байна.

Хүчин чадал, бодит хүүхдийн тооноос хэтрүүлэн хувьсах зардлын болон үдийн цай, хоолны санхүүжилт аваагүй байна.

Тус сургууль түрээсийн орлогын өглөг, авлагын тооцоо зөрүүтэй тул санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Олгосон санхүүжилтийг тайлант онд зарцуулж дуусгах зорилгоор оны эцэст үр ашиггүй худалдан авалт хийгээгүй, нөөц үүсгээгүй байна.

Аймаг, сумын Засаг дарга нарын шийдвэрээр улсын төсвийн хөрөнгийг зарцуулаагүй байна. Спортын заалтай боловч түрээсэлдэггүй, урлагийн заал, усан бассейн, цайны газаргүй.

Үдийн цай хөтөлбөрийг байгууллага өөрийн хүчин чадлаар хэрэгжүүлж байна.

Үдийн цай хөтөлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдэлгүй ба байгууллага өөрөө хэрэгжүүлдэг тул зарцуулагдаагүй хүнсний материалын үлдэгдэлтэй гарсан байна.

Эцэг эхээс болон бусад байгууллага, хувь хүнээс хандив аваагүй байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/024/11 дүгээр тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишгийг баримталж ажиллаж байгаа боловч сан ба нийгмийн ажилтны 1, үйлчилгээний 2 ажилтны орон тоо дутуу байна. Батлагдсан орон тооны хязгаарыг баримталж ажилласан 2024 оны батлагдсан тоо 15, гүйцэтгэл 15 байна.

Сургууль нь ахмадын сангийн харилцах данс нээлгээгүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад мэдээлсэн байдлын хэрэгжилт 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил илрээгүй.

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлүүд холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, дотуур байрны хоолны нормативыг хэтрүүлсэн зөрчлүүдэд албан шаардлага өгөгдсөн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	952,789.8	2	952,789.8	100%
Зөвлөмж					
Нийт дүн	2	952,789.8	2	952,789.8	100%

Тайлант оны аудитаар давтан шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 17.7 сая төгрөгийн алдаа¹ илэрч, аудитын явцад 17.7 сая төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: 1. Аудитын тулгалтаар нийгмийн даатгалын шимтгэлийн, ХХОАТ-ын өр төлбөрийг 16.4 сая төгрөгөөр дутуу бараа үйлчилгээний зардлын өглөгийг 3346 төгрөгөөр илүү тайлагнасныг санхүүгийн тайланд залруулсан.

2. Тайлант оны үр дүнг 123.5 сая төгрөгөөр илүү тайлагнасныг санхүүгийн байдлын болон үр дүн, өмчийн өөрчлөлтийн тайлангуудад залруулсан.

3. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тайлант оны гүйцэтгэлийг 7.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/З дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 4.7 сая төгрөгийн зөрчил² илэрч, 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1. Сургуулийн захирлын тушаалаар боловсролын тэргүүний ажилтан, яамны жуух бичгээр шагнагдсан багш нарт олгосон 4,700.0 мянган төгрөгийн, Улаанбаатар хотод болсон волейболын тэмцээнд амжилттай оролцсон багш нарт олгосон 1,600.0 мянган төгрөгийн, нийт 6,300.0 мянган төгрөгийн шагналын мөнгөнөөс ХХОАТ-ын тухай хуульд заасны дагуу татвар суутгаж төвлөрүүлээгүй.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-т “суутган төлөгч” гэж Татварын ерөнхий хуулийн 6.1.19-д заасныг”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна”, 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шагнал авсан багш нарын цалингаас хуульд заасан хувиар ХХОАТ суутгаж төсөвт төвлөрүүлэх.

5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 4.1 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

1. Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б/42 дугаар тушаалаар нягтлан бодогч, нярав нарт газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 2,513,000 төгрөгийн урамшуулал, аймгийн Боловсролын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Б/100 дугаар тушаалаар сургуулийн захиралд 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан гэж 1,544,000 төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтыг хэтрүүлэн урамшуулал олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газраас тогтоосон журмыг баримталж мөнгөн урамшууллыг тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх талаар албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /дотуур байрны хоол хүнс 183.8 сая төгрөг, үдийн хоол 102.6 сая төгрөг г.м/ байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
НДШ,ХХОАТ-ын өр төлбөрийг дутуу, бараа үйлчилгээний зардлыг 3346 төгрөгөөр илүү тусгасан	1	16,436.4	1	16,436.4			1	16,436.4				
Тайлант оны үр дүнг 123.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан.	1	123,521.8			1	123,521.8	1	123,521.8				
Төсвийн гүйцэтгэлийг 7.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	7,573.7			1	7,573.7	1	7,573.7				
Дүн	3	147,531.9	1	16,436.4	2	131,095.5	3	147,531.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал
					Үүнээс		

Сагсай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шагналын мөнгөнөөс төсөвт ХХОАТ суутгаж төвлөрүүлээгүй.	1	630.0	1	630.0								
Захирал, нягтлан бодогч, нярав нар 4,057.0 мянган төгрөгийн балансын шагнал авсан.	1	4,057.0			1	4,057.0						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй	1						1					
Дүн	3	4,687.0	1	630.0	1	4,057.0	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								